

ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 05-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Тооллогын

дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 67.3.1, 68.4 дэх заалтууд болон Компанийн дүрэм, 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Гермес Центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 42 540 145 саналын эрхтэй 2 хувьцаа эзэмшигч, мөн хуралд биечлэн оролцож байгаа 25 263 012 саналын эрхтэй 13 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул тооллогын дүнг хавсралтын дагуу баталж, ээлжит хурлын дарга (Д.Оюунсүрэн)-д танилцуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН



О.Золжаргал
О.ЗОЛЖАРГАЛ

Г.Мандалцэцэг
Г.МАНДАЛЦЭЦЭГ

Б.Чимэгээ
Б.ЧИМЭГЭЭ



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Тооллогын

дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, Компанийн дүрэм, 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь :

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй 86.32 хувийн хувьцаа эзэмшигчид (хавсралт №1) оролцсон тул хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсугай.
2. Хурлын ирц хангалттай тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.



ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 5 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг үндэслэн “Гермес Центр” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн өгсөн дүгнэлтийг хавсралтын дагуу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын 2 тоот тогтоолын хавсралт

КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАНД ТУЗ-ӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Гермес Центр” ХКомпани нь 2023 онд бүтэц зохион байгуулалтын хувьд 16 ажилтан ажиллагсадтайгаар батлагдсан төсөв төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

Тус компани нь 2023 онд 1,698.3 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бөгөөд тухайн жилийн ашгийн төлөвлөгөөтэй харьцуулахад 8%-иар буюу 126.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Мөн нэгж хувьцаанд оногдох ашиг 21 төгрөг 62 мөнгө болсон бөгөөд ногдол ашгийн төлөвлөгөөтэй харьцуулахад 8%-иар буюу 1 төгрөг 61 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан байна.

Тиймд гүйцэтгэх удирдлагын багийн 2023 онд тавьсан зорилго, зорилтуудаа биелүүлж, амжилттай САЙН ажилласан хэмээн ТУЗ-өөс дүгнэж байна.

ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20²⁴ оны 04 сарын 5 өдөр

Дугаар ...3

Улаанбаатар хот

ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг үндэслэн **ТОГТООХ** нь :

1. “Гермес центр”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчийн 100 %-ийн саналаар хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН